



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Булган сум

Төсвийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 281 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн 2024 оны төсвийн орлогын сарын хуваарийг 1 дүгээр, 2024 оны сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн сарын хуваарийг 2 дугаар, 2024 оны сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хуваарийг 3 дугаар, 2024 оны сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хуваарийг 4 дүгээр, 2024 оны орон нутгийн төсвөөс санхүүжих байгууллагуудын сарын хуваарийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ